



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/БЧН

Арвайхээр

Нэгдсэн арга хэмжээ зохион явуулах
тухай


Галт зэвсгийн тухай хуулийн 22 дүгээр зүйлийн 22.1, Хууль зүйн сайдын 2015 оны “Галт зэвсгийн тооллого явуулах журам батлах тухай” А/220 дугаар тушаал, “Журам батлах тухай” А/219 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Галт зэвсгийн тооллого явуулах журам”, “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах, бүртгэлгүй, нуугдмал галт зэвсгийг илрүүлэх, галт зэвсэг, сумны хууль бус худалдааг таслан зогсоох, татвар, төлбөрийг төвлөрүүлэх зорилгоор “Зэвсэг” нэгдсэн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд зохион явуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн газраас баталсан удирдамж, төлөвлөгөө болон захирамжийн дагуу сумдад зохион явуулахыг аймаг дахь Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтэс (Н.Эрдэнсүвд), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Сумдыг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үр дүнг тооцон 2019 оны 11 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101195